

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/13/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorlooga@audit.gov.mn](mailto:ichinkhorlooga@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	2
Аудитын гол асуудал .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	11
4.1 Ерөнхий зүйл .....	11
4.2 Материаллаг байдал .....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.5.1 Завсрын аудитын талаар .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
5. Аудитын илрүүлэлт .....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.06 № 01/48  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Б.МӨНГӨНЗУЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хөрөнгийн шинж чанар бүхий 16.9 сая төгрөгийн бараа материалыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр үндсэн хөрөнгөд орлого авч тайлагнасан байна.

### Аудитын гол асуудал

Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 213.6 сая төгрөгийн орлогыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт төвлөрүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Улсын бүртгэлийн ерөнхий газартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 зорилт, 30 арга хэмжээний хэрэгжилт 90.6 хувьтай үнэлэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт

олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,923,820.92</b>	<b>84,625,077.33</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>8,244.00</b>	<b>19,940,050.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>8,244.00</b>	<b>19,940,050.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	8,244.00	19,940,050.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>69,915,576.92</b>	<b>64,685,027.33</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>16,548,617.92</b>	<b>31,629,033.33</b>
35110	Тусгай зориулалттай материал	16,548,617.92	31,629,033.33
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,848,483.00	7,562,518.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>44,518,476.00</b>	<b>25,493,476.00</b>
35410	Бичиг хэргийн материал	45,000.00	45,000.00
35420	Аж ахуйн материал	29,327,460.00	21,582,460.00
35470	Бусад хангамжийн материал	15,146,016.00	3,866,016.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>838,173,921.99</b>	<b>839,193,902.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>838,173,921.99</b>	<b>839,193,902.93</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>825,388,921.99</b>	<b>826,408,902.93</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	630,016,659.00	630,016,659.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,738,157.28	-66,317,543.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,300,000.00	29,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,300,000.00	-29,300,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	327,565,267.44	354,998,918.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-87,767,656.89	-97,812,346.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,828,250.00	39,074,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,515,440.28	-33,551,385.19
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>12,785,000.00</b>	<b>12,785,000.00</b>
39301	Программ хангамж	7,854,850.00	7,854,850.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,854,850.00	-7,854,850.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,785,000.00	12,785,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>908,097,742.91</b>	<b>923,818,980.26</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>908,097,742.91</b>	<b>923,818,980.26</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>908,097,742.91</b>	<b>923,818,980.26</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,785,000.00	12,785,000.00
51101	Өмч: - төрийн	12,785,000.00	12,785,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>885,042,122.67</b>	<b>900,763,360.02</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	885,042,122.67	885,042,122.67
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,721,237.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,270,620.24	10,270,620.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>908,097,742.91</b>	<b>923,818,980.26</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,092,289,463.48</b>	<b>798,145,784.20</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>299,047,863.48</b>	<b>111,462,884.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>299,047,863.48</b>	<b>111,462,884.20</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	299,047,863.48	78,737,634.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	299,047,863.48	75,546,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>793,241,600.00</b>	<b>686,682,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>677,006,200.00</b>	<b>681,087,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	677,006,200.00	681,087,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>116,235,400.00</b>	<b>5,595,600.00</b>

131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,135,400.00	5,595,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>889,002,964.21</b>	<b>765,428,546.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>889,002,964.21</b>	<b>765,428,546.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>884,268,241.21</b>	<b>761,770,986.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>540,699,700.00</b>	<b>518,273,718.00</b>
210101	Үндсэн цалин	430,601,781.00	416,328,013.00
210102	Нэмэгдэл	99,085,899.00	91,034,462.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,012,020.00	10,911,243.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,084,204.31</b>	<b>65,613,491.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	52,827,304.31	44,478,511.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,814,200.00	5,286,841.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,851,400.00	4,226,193.39
210204	Ажилгүйдлийн даатгал	962,800.00	1,056,448.29
210205	Эрүүл мэндийн даатгал	9,628,500.00	10,565,495.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,739,100.00</b>	<b>44,041,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,951,055.00	5,695,431.00
210302	Түлш, халаалт	33,795,031.00	35,914,848.00
210303	Цэвэр, бохир ус	993,014.00	2,431,121.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>55,118,813.00</b>	<b>32,514,500.00</b>
210401	Бичиг хэрэг	7,500,400.00	10,389,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,131,000.00	3,443,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,595,500.00	3,137,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	153,000.00	310,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,989,400.00	15,233,800.00
210408	Бараа материал акталсны зардал	11,749,513.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,819,900.00</b>	<b>2,544,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	891,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	113,400.00	1,034,700.00
210604	Урсгал засвар	4,456,500.00	618,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>298,200.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	298,200.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,103,183.28</b>	<b>14,517,324.59</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	796,200.00	2,590,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	244,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	100,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,086.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	38,325.00	38,325.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,021,572.28	11,442,799.59
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>157,405,140.62</b>	<b>84,266,553.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,135,400.00	5,595,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,118,000.00	953,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,151,740.62	77,717,653.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,734,723.00</b>	<b>3,657,560.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>412,800.00</b>	<b>1,344,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	412,800.00	1,344,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,221,923.00</b>	<b>2,313,360.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,221,923.00	2,313,360.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	100,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	203,286,499.27	32,717,237.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	16,996,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	16,996,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-16,996,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	203,286,499.27	15,721,237.35

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,785,000.00	10,270,620.24	679,353,921.92	702,409,542.16
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,785,000.00	10,270,620.24	679,353,921.92	702,409,542.16
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	203,286,499.27	203,286,499.27
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,785,000.00	10,270,620.24	885,042,122.67	908,097,742.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,785,000.00	10,270,620.24	885,042,122.67	908,097,742.91
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,721,237.35	15,721,237.35
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,785,000.00	10,270,620.24	900,763,360.02	923,818,980.26

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,085,712,937.00	899,866,372.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	292,471,337.00	213,183,472.45
120	Нийтлэг татварын бус орлого	292,471,337.00	213,183,472.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	292,471,337.00	213,183,472.45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	292,471,337.00	213,183,472.45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	793,241,600.00	686,682,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	677,006,200.00	681,087,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	677,006,200.00	681,087,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	116,235,400.00	5,595,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,135,400.00	5,595,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,082,525,087.00	899,866,372.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,082,525,087.00	899,866,372.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	788,506,877.00	683,025,340.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,699,700.00	518,273,718.00
210101	Үндсэн цалин	430,601,781.00	416,328,013.00
210102	Нэмэгдэл	99,085,899.00	91,034,462.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,012,020.00	10,911,243.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,027,766.00	65,609,297.00
210201	Тэтгэврийн даатгал	52,770,866.00	44,474,317.72
210202	Тэтгэмжийн даатгал	4,814,200.00	5,286,841.68

**Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,851,400.00	4,226,193.39
210204	Ажилгүйдлийн даатгал	962,800.00	1,056,448.29
210205	Эрүүл мэндийн даатгал	9,628,500.00	10,565,495.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,739,100.00</b>	<b>44,041,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,951,055.00	5,695,431.00
210302	Түлш, халаалт	33,795,031.00	35,914,848.00
210303	Цэвэр, бохир ус	993,014.00	2,431,121.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,636,600.00</b>	<b>21,072,500.00</b>
210401	Бичиг хэрэг	3,746,800.00	10,227,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,131,000.00	3,443,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,595,500.00	3,137,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	153,000.00	310,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,010,300.00	3,953,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,770,500.00</b>	<b>24,405,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,600.00	22,752,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	113,400.00	1,034,700.00
210604	Урсгал засвар	4,456,500.00	618,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>298,200.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	298,200.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,081,611.00</b>	<b>3,074,525.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	796,200.00	2,590,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	244,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	100,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,086.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	38,325.00	38,325.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>117,253,400.00</b>	<b>6,548,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,135,400.00	5,595,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,118,000.00	953,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>294,018,210.00</b>	<b>216,841,032.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>412,800.00</b>	<b>1,344,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	412,800.00	1,344,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>293,505,410.00</b>	<b>215,496,832.45</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,221,923.00	2,313,360.00
213304	Хөрөнгийн	289,283,487.00	213,183,472.45
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>100,000.00</b>	<b>00.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3,187,850.00</b>	<b>00.00</b>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,187,850.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	/ төгрөгөөр /		
			Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	681,087,300.0	678,773,940.0	2,313,360.0	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,087,300.0	678,773,940.0	2,313,360.0	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	679,743,100.0	677,429,740.0	2,313,360.0	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,274,900.0	518,273,718.0	1,182.0	100.0
210101	Үндсэн цалин	430,028,800.0	416,328,013.0	13,700,787.0	96.8
210102	Нэмэгдэл	75,838,100.0	91,034,462.0	-15,196,362.0	120.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,408,000.0	10,911,243.0	1,496,757.0	87.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,909,300.0	65,609,297.0	2,300,003.0	96.6
210201	Тэтгэврийн даатгал	46,178,400.0	44,474,317.7	1,704,082.3	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,432,700.0	5,286,841.7	145,858.3	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,346,200.0	4,226,193.4	120,006.6	97.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,086,500.0	1,056,448.3	30,051.7	97.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,865,500.0	10,565,495.9	300,004.1	97.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,041,400.0	44,041,400.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,863,200.0	5,695,431.0	-832,231.0	117.1
210302	Түлш, халаалт	37,165,800.0	35,914,848.0	1,250,952.0	96.6
210303	Цэвэр, бохир ус	2,012,400.0	2,431,121.0	-418,721.0	120.8
2104	Хангамж, бараа материалын зардал	21,072,500.0	21,072,500.0	00.0	100.0
210401	Бичиг хэрэг	10,227,800.0	10,227,800.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,443,100.0	3,443,100.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,137,200.0	3,137,200.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	310,600.0	310,600.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,953,800.0	3,953,800.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,405,000.0	24,405,000.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,752,300.0	22,752,300.0	00.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,034,700.0	1,034,700.0	00.0	00.0
210604	Урсгал засвар	618,000.0	618,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,086,700.0	3,074,525.0	12,175.0	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,590,300.0	2,590,300.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	244,300.0	244,300.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	100,800.0	100,800.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.0	100,800.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	50,500.0	38,325.0	12,175.0	75.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	953,300.0	953,300.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	953,300.0	953,300.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,344,200.0	1,344,200.0	00.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,344,200.0	1,344,200.0	00.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,344,200.0	1,344,200.0	00.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>681,087,300.0</b>	<b>678,773,940.0</b>	<b>2,313,360.0</b>	<b>100.0</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>681,087,300.0</b>	<b>678,773,940.0</b>	<b>2,313,360.0</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	681,087,300.0	678,773,940.0	2,313,360.0	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>44.00</b>	<b>44.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /		
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,595,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,595,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,595,600.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,595,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,595,600.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,595,600.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,595,600.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,595,600.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж хэрэгжүүлэхэд оршдог ба улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх, мэдээллийг хэрэглээнд оруулах дундын өгөгдлийн системийг бий болгон хөгжүүлэх, бүртгэлийн мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна гэж дүгнэлээ.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2022 оны А/12 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод хяналтын зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2022 оны 9 дүгээр сарын 21-нд хэлтсийн даргаар батлуулсан байна. Тус зөвлөл нь 2022 онд нийт 6 асуудалд дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Дотоод хяналтын ажлын гүйцэтгэлийг хянаж үзэхэд 2022 онд гол төлөв иргэний болон эд хөрөнгийн бүртгэл, архивын үйл ажиллагаа, иргэд албан байгууллагуудаас ирсэн албан бичиг, өргөдөл гомдлын хүрээнд холбогдох ажлуудыг хамтран зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан талаар тайланд дурдсан байна.

Тус байгууллагад дотоод аудитыг Улсын бүртгэлийн ерөнхий газраас хяналт тавьж хэрэгжүүлдэг ба тайлант онд ерөнхий газраас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/87 тушаалаар баталж мөрдсөн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.7 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	0.0	19.9	19.9
Бараа материал	69.9	64.7	(5.2)
Үндсэн хөрөнгө	825.4	826.4	1.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12.8</b>	<b>12.8</b>	<b>-</b>
<b>Эздийн өмч</b>	<b>908.1</b>	<b>923.8</b>	<b>15.7</b>
-терийн	<b>12.8</b>	<b>12.8</b>	<b>-</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10.3	10.3	-
Хуримтлагдсан үр дүн	885.0	900.8	15.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>908.1</b>	<b>923.8</b>	<b>15.7</b>

Нийгмийн даатгалын хэлтсээс 4050 төгрөгийн авлагатай байгаа ба харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулсан байна. Бараа материалыг 2023 оны 1 дүгээр улиралд нийлүүлэхээр гэрээ хийж, 19.9 сая төгрөгөөр авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.2 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал болон бусад хангамжийн материал дээр байсан 16.9 сая төгрөгийн хөрөнгийн шинж чанар бүхий зүйлсийг ТӨБЗГ-ийн А/163 тушаалаар үндсэн хөрөнгөд орлого авсан, Ковидын үед Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон байсан ариутгалын материалуудыг тайлант онд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2022 оны А-1/1950 тоот албан бичиг, 673 тоот тогтоолын дагуу 3.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас шилжүүлэн авсан.
- ТӨБЗГ-ын 2022 оны 637 тоот тогтоолоор 4.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэ тогтоож орлого авсан.
- ТӨБЗГ-ын 2022 оны а-1/2576 тоот албан бичгээр 20.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж тавилгыг акталсан байна.
- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 53.6 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг Киоск машиныг үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Хуримтлагдсан үр дүн данс 15.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,235.7 сая, нийт зарлагыг 1,235.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 51.7 сая, их засварын зардлыг 477.9 сая төгрөгөөр бууруулж, 706.1 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн төлөвлөлтөд тусгагдсан их засварын зардлыг батлаагүй байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 706.1 сая төгрөгийг баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 25.0 сая төгрөгийн төсвийн зохицуулалт хийж 681.1 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 681.1 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч, 678.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 2.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70406</b>	<b>Улсын бүртгэл мэдээлэл</b>	<b>681.1</b>	<b>678.8</b>	<b>2.3</b>	<b>99.7</b>
80101	Үндсэн үйл ажиллагаа	679.7	677.4	2.3	99.7
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1.3	1.3	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд УБЕГ-аас орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулж хуваарилсан 5.6 сая төгрөгийн нэмэлт орлого хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд 5.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 1/81 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардал 889.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 14.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд хугацаа хоцроож оруулсан мэдээлэл байхгүй байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны А/368 дугаар тушаалаар орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд Хөвсгөл аймагт нийт 5.6 сая төгрөгийн төсвийг хуваарилж, зориулалтын дагуу зарцуулсан байна. Нийт зардлын 46.4 хувийг улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал, 42.8 хувийг техник хэрэгсэл тээвэрлэх болон сургалтын зардал тус тус эзэлж байна.

Иргэний болон эд хөрөнгийн баримтын архивын тооллогыг 2022 оны 5 - 12 дугаар сарын хугацаанд зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулан гүйцэтгэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	96.0	1	96.0	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>96.0</b>	<b>1</b>	<b>96.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар байгууллагын дотоод хяналтыг оновчтой хэрэгжүүлэх 1 зөвлөмжийг хүргүүлж байна.

#### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

#### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналтын зөвлөл нь төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж хийж илэрсэн алдаа зөрчилд зөвлөмжийг өгч ажилласан боловч хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлуулахдаа Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1-д заасан чиглэлийг баримтлах, алдаа зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх	1						1						
Дүн	1						1						

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

